

## ДОРНОД АЙМАГ ДАХЬ ЧОЙБАЛСАН НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ДОТООД АУДИТ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТОВЧ ТАЙЛАН

2020.10.14

Хэрлэн сум  
8 дугаар баг

ИНЕГ-ын даргын баталсан 2020 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн ИНЕГ-ын харьяа Дорнод аймаг дахь Чойбалсан нисэх буудлын үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх тухай 27/20 тоот удирдамжийн хүрээнд дотоод аудит, хяналт шалгалтыг хийлээ.

Батлагдсан удирдамжийн дагуу ИНЕГ-ын ДАА-ны ахлах аудитор Л.Жаргалсайхан, санхүүгийн хяналтын мэргэжилтэн Б.Болормаа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдрийг дуустал хугацаанд дотоод аудитыг хийсэн.

ИНЕГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд Дорнод аймаг дахь Чойбалсан нисэх буудлын 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг дуустал хугацааны үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журам болон дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт, нягтлан бодох бүртгэл, цалин хөлсний бодолт, олголт, төсөв гүйцэтгэл, дотоод хяналт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус багийн үйл ажиллагаа, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэргийг үндсэн баримт нотолгоонд тулгуурлан шалгах, зарим эргэлзээтэй зүйлүүд дээр холбогдох албан тушаалтнаас тайлбар, тодруулга авч ажиллалаа.

2019 онд ИНЕГ, Тагнуулын ерөнхий газартай хамтран “Нисэх буудлын барилга, байгууламжийг тэсрэх хэрэгслээр заналхийлсэн үйлдлийн үед хэрэгжүүлэх хариу арга хэмжээ” /Код-7/ сэдэвт онцгой байдлын бүрэн хэмжээний дасгал сургуулилтыг амжилттай зохион байгуулсан байна.

Нисэх буудлын 2019 оны санхүүгийн тайланд МУ-ын Төрийн аудитын тухай хуулийн холбогдох заалтын дагуу Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд тус газрын захиалга гэрээний дагуу Хаан консалтинг Аудит ХХК аудит хийж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргасан байна.

Ажилтнуудын хувийн хэргийн бүрдүүлэлт, хөтлөлт, баяжилт, эмх цэгц сайн байна.

Цалин хөлс, түүнтэй адилтгах бусад мөнгөн тооцоотой холбоотой татвар, шимтгэлийн тайланг хуулийн хугацаанд тооцоо нийлж баталгаажуулсан.

Дизель генераторуудын ажиллагаа жигдэрсэн, тухайн сард ажилласан мото/цагийн заалттай тулгасны үндсэн дээр шатахууны тооцоог хийж байна. Цахилгаан тасарсан үед аймгийн эрчим хүчний газраас тухай бүр тодорхойлолтыг авч хэвшсэн байна. Түлш шатахууны тооллогоор тооллогоор зөрчил илрээгүй.

Нисэх буудлын удирдлага болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дэд зөвлөл хууль, тогтоомж болон Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дүгээр тушаал, Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 253 дугаар тушаалуудыг өөрийн нэгж дээр хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Тушаалын тэргүүг буруу бичих, буруу дугаарлах, тушаалын бичвэр үг, үсэг, утга, найруулгын алдаа ихтэй байна. Албан бичгийн тэргүүг хэвлэмэл хуудсанд тавьсан тэмдэглэгээнд багтааж, стандартын дагуу бичигдээгүй, тэмдэглэгээний дээр бичигдсэн эсвэл тэмдэглэгээнээс илүү гарган бичсэн, “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын 2.4 дүгээр зүйлийг мөрдөж ажиллаагүй байна.

Өргөдөлд бүртгэл хяналтын карт хөтөлдөггүй зөрчил нийтлэг байх ба бүртгэл хяналтын карт хөтөлсөн өргөдөлд шийдвэрлэлтийн байдлыг бичдэггүй.

Ажилчдын ажилдаа ирсэн, явсан цагийн бүртгэлийг буруу, дутуу хөтлөжээ. 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хурууны хээгээр цагийн бүртгэлийг хийдэг болсон ба бүртгэл дээр ажилчдын нэр байхгүй, ажиллагсдын нэрний оронд код буюу тоо гарч ирэх боловч ямар код нь хэнийх болох нь тодорхойгүй байна. Хурууны хээний бүртгэл дутуу байна.

Бараа материалын агуулахын эмх цэгц муу, хадгалалт хамгаалалт, хаягжуулалт хангалтгүй байна.

2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2019 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацааны орон нутаг дахь нисэх буудлуудаас 7 хоног тутам ирүүлдэг “Үл тохирлын мэдээ”-г ирүүлсэн байдалд НБУГ-аас хяналт хийж, үр дүнг дүгнэсэн байдлаас харахад Чойбалсан нисэх буудал 13 долоо хоног буюу хамгийн удаан мэдээ ирүүлээгүй, мэдээ тайлагналтын гүйцэтгэл 71.8 хувь буюу хамгийн муу үзүүлэлттэй байна.

Цагийн бүртгэлийг хянахдаа хариуцлагагүй хандсан, цалинтай чөлөөг ажилласан хоногт оруулж бүртгэлийг гаргасантай холбоотойгоор хоолны үнийн хөнгөлөлт илүү олгогдсон.

Албан томилолтоор ажилласан ажилтнуудад хоолны үнийн хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.

Аюулгүй байдлын шалгагч-бичиг хэрэг Ж.Золжаргалыг ажлаас чөлөөлөгдөхөд ээлжийн амралтын буюу эцсийн тооцоог хийгээгүйгээс илүү олгогдсон ээлжийн амралтын олговрыг суутган тооцоогүй байна.

Туршилтын гэрээтэй ажилтанд үр дүнгийн нэмэгдэл олгожээ.

Ажилтанд үр дүнгийн нэмэгдэл олгохдоо шууд удирдах нэгжийн даргын тодорхойлж, үр дүнгийн хуудсанд баталгаажуулсан хувиас өөр дүнгээр тооцож олгох, иргэний нисэхийн салбарт ажилласан жилийг буруу тооцож гаргаснаас 1 ажилтанд 275,993.28 төгрөгийн, удаан жил ажилласан хугацааг буруу тооцох, нэмэгдэл хувийг буруу тооцсон зэргээс шалтгаал цалин хөлсний тооцоогоор зөрчил гарсан байна.

Бичиг хэрэг хариуцсан ажилтан ажилтны ажилласан жилийн тооцоог гаргахдаа нийгмийн даатгалын шимтгэл төлж, баталгаажуулсан бичилтийг үндэслэн удаан жилийн нэмэгдлийг тооцоог гаргаагүй байна.

“Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын 2.4.5.1, 2.4.5.3-д заасан заалтуудыг зөрчиж гэрээ байгуулахдаа огноо тавиагүй, эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зураагүй, гэрээний бүртгэлийн дэвтэр хөтлөөгүй, гэрээг дүгнээгүй зөрчил нийтлэг байна.

Шилэн дансны мэдээллийг буруу оруулах, мэдээлэхгүй байх зөрчил давтагдсаар байна.

Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбарыг хавсаргаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь заалтыг зөрчсөн байна.

Дотоод хяналтын багийн гишүүдийн хяналт тавих, шалгалт хийх ажлын туршлага, мэдлэг хангалтгүй байгаагаас хяналт шалгалтын үр дүн муу, тайлан бичилт хангалтгүй байна. Дотоод хяналтын багийн гишүүдийн ур чадварыг сайжруулах, дахин сургалтад хамруулах шаардлагатай ба багийн гишүүд өөрсдийгөө дайчлах, суралцах тал дээр санаачилга гаргаж ажиллах хэрэгтэй байна.

Галын бүлгэмийг тушаалаар албажуулж томилоогүй байна.

Байгууллагын нэр дээрх орон сууцыг эзэмшүүлэх гэрээг хугацаагүйгээр байгуулсан байгаа нь ...төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 1 /нэг/ хүртэл жилийн хугацаагаар холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн байгуулна... гэж заасныг зөрчжээ.

Аудитын шалтгалтын үр дүнд гарсан алдаа, дутагдлыг арилгах, залруулах талаар Иргэний нисэхийн үндэсний төвд 1, тус нисэх буудалд 19, нийт 20 зөвлөмж өгсөн болно.

## ДОТООД АУДИТЫН АЛБА